

ЦАХИМ УР ЧАДВАР

СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ ТОВХИМОЛ



ЦАХИМ
ҮНДЭСТЭН



ЦАХИМ УР ЧАДВАР

Суурь мэдлэг олгох товхимол

Энэхүү товхимлыг Цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн болгон суралцагчид зориулсан болно. Товхимлыг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, бусад хэлбэрээр ашиглах бол эх сурвалжийг заавал дурдана уу.

“И Монгол академи” УТҮГ
Цахим ур чадвар хөгжүүлэлтийн алба









Улаанбаатар хот
2022 он

■ Цахим ур чадвар гэж юу вэ?

Цахим технологи, интернэт сүлжээнд холбогдсон төхөөрөмж ашиглан өөрт хэрэгтэй мэдээллээ тодорхойлох, олж авах, түүнийгээ үнэлэх, хуваалцах, нэгтгэх, шинээр бий болгох замаар нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох чадварыг хэлнэ.

Эх сурвалж: ЮНЕСКО

Цахим иргэн болоход шаардлагатай чадварууд

-  Цахим орчноос хүссэн зөв мэдээллээ хайж, олж авах;
-  Цахим орчинд худалдан авалт хийх;
-  Цахим орчинд бусдыг хүндэлж, ёс зүйтэй хандах;
-  Интернэт, нийгмийн сүлжээг зохистой хугацаанд хэрэглэх;
-  Хувийн мэдээллээ хамгаалах;
-  Цахим орчинд ташаа мэдээлэл түгээхгүй байх;
-  Орчин үеийн шинэ технологи, ухаалаг төхөөрөмж ашиглах;
-  Цахим орчинд бусадтай харилцах;

Санамж:

Таны интернэт болон нийгмийн сүлжээнд хийж буй үйлдэл, хуваалцсан мэдээлэл бүхэн хадгалагдан үлддэгийг анхаараарай.

■ Худал мэдээ, мэдээллийг таних

Кино шууд үзэх 2021
August 13 at 11:40 AM · 🌐

Шуурхай мэдээ: Чингис хааны онгоныг оллоо гэв

МОНГОЛИАН
FACT
CHECKING
CENTER

ХУДАЛ

Олон нийтийн анхаарлыг татсан гарчиг, зурагтай мэдээллийг дахин сэргээж постолж, хандалт цуглуулдаг тохиолдлуудын нэг нь "Чингис хааны онгоныг оллоо" гэх мэдээлэл юм.

Мэдээллийн эх сурвалжийг шалгах

Агуулгыг нь нягтлах

Жинхэнэ хаяг эсэхийг шалгах

Баримт нотолгоотой эсэхийг шалгах

Нийтэлсэн он, сар, өдрийг нь шалгах

Өмнө нь оруулсан линкээ устгасан байдал

Facebook | Twitter | Reddit | Instagram

NUMBER OF FOLLOWERS	DATE	INTERACTIONS
500+		109,545
Шинэ хошин шөг	Aug 27, 2022	4,660
Кино шууд үзэх 2021	Jun 25, 2022	4,960
Шинэ хошин шөг	Aug 26, 2022	2,661
Кино шууд үзэх 2021	Jul 20, 2022	2,660

Эх сурвалж: Mongolian Fact Checking Center



Та үндэслэлгүй худал мэдээлэлд итгэснээр эдийн засаг, сэтгэл зүй болон биеийн эрүүл мэндээрээ хохирно!!!

■ Мэдээллийн аюулгүй байдал гэж юу вэ?

Мэдээллийн аюулгүй байдал нь зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээлэлд хандах, ашиглах, дэлгэх, алдагдуулах, өөрчлөх, хуулбарлах, устгахаас сэргийлэх дадал юм.

Эх сурвалж: Компьютерын аюулгүй байдлын төв

Тухайн хувь хүн, байгууллагатай холбоотой бүхий л мэдээллийг хувийн мэдээлэл гэнэ.

Хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлэх:

- Нууц үгээ тогтмол сольж байх;
- Хувийн и-мэйл хаяг, систем бүрд өөр нууц үг ашиглах;
- Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хуваалцахдаа болгоомжтой хандах;
- Хувийн болон албаны мэдээллээ ангилах, нөөцлөх;
- Цахим орчинд төлбөр тооцоо хийх тохиолдолд тухайн веб сайтыг баталгаатай эсэхийг шалгах;
- Программ, аппликэйшнийг найдвартай эх сурвалжаас татах;
- Танд ирж буй цахим шууданд болгоомжтой хандах;
/Зарим нэг холбоос, зургууд цаанаа халдлагын шинжтэй байдаг/
- Хамгаалалтгүй, төлбөргүй утасгүй интернэт (WiFi) нь таны хувийн мэдээллийг хулгайлах гол хэрэгсэл болдог;
- Флаш, SD карт зэрэг зөөврийн төхөөрөмжийг өөрийн компьютерт холбохдоо вирусны программаар шалгах;
- Өөрийн төхөөрөмж дэх программ хангамжийг тогтмол шинэчилж цахим аюул, халдлагаас урьдчилан сэргийлэх.

Баталгаат нууц үг:

- Боломжит хамгийн урт байдлаар хийх;
- Том, жижиг үсэг, тоо, тэмдэгтүүдийг хольж хэрэглэх;
- Таны нэр, төрсөн он, сар, гэр бүлийн гишүүний нэр буюу хувийн мэдээлэл агуулаагүй байх;

Муу нууц үг	Дундаж нууц үг	Маш сайн нууц үг
tsahimirgen	Tsahimirgen01	Ts@him_irgen12
ilovefamily	ILove3MyFamily	IL*v3MyF4m1ly
internet	Int*rnet	Int*er_Net3
uhaalagtohoormj	uhaalagtohoorumj2022	Uh@!@!gT0h00r0m!

■ Нийгмийн сүлжээнд ёс зүйтэй оролцох

Бусдын үзэл бодлыг хүндэтгэх

Бусдын нэр хүндэд халдахгүй байх

Зөв зохистой үг, хэллэг ашиглах

Бусдад түгээхээсээ өмнө эх сурвалжийг шалгах

Бусдын хувийн амьдралыг хүндэтгэх

Спам мессеж явуулахгүй байх

Өөрийн үзэл бодлоо зөв илэрхийлэх



■ Цахим худалдаа хийхэд анхаарах зүйлс



Бүтээгдэхүүний гадаад үзэмжид хууртахгүй байх;



Цахим орчны сурталчилгаанд хэт автахгүй байх;



Цахим хуудас болон фэйсбүүк хуудсыг шалгаж, нягтлах;



Хэрэглэгчийн сэтгэгдлийг унших;



Төлбөр төлөхдөө картын мэдээллээ оруулахаас зайлсхийх;



Буцааж болох эсэхийг урьдчилан тодруулах;



Захиалга зөв хаягаар ирж байгаа эсэхийг шалгах;



Бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг шалгах;

■ Тоон гарын үсэг

Тухайн баримт бичиг, мэдээллийг баталгаажуулж, хүлээн зөвшөөрсөн хувь хүний гарын үсгийн цахим хэлбэр юм.

Эх сурвалж: Европын Комисс

Тоон гарын үсгийг иргэдэд олгосноор дараах давуу талууд бий болно.

- Нууцлал, аюулгүй байдлаа хамгаална.
- Хялбар үйлчилгээ авна.
- Стандартад нийцтэй олон улсад шалгарсан шийдэл.

Тоон гарын үсэг олгох үйл явц:



Ухаалаг гар утсандаа GSign аппликейшнийг татна.




Улсын бүртгэлийн ажилтнаас өгсөн эсвэл киоск машин дээр гарч ирсэн QR кодыг уншуулна.



Мессежээр ирсэн 6 оронтой кодыг утсан дээрээ оруулна.



Гарын үсэг зурж баталгаажуулах үед оруулж байх ПИН кодыг шинээр өөрөө зохиож оруулна.



ПИН кодыг давтан оруулна.



Пин код баталгаажуулах үед ПИН кодоо сэргээх ПУК кодыг системээс автоматаар үүсгэж өгнө.

Тус кодыг хадгалахаа мартуузай

Санамж:

Иргэний үнэмлэхтэйгээ ирж тоон гарын үсгээ авна.



E-Mongolia руу тоон гарын үсгээр нэвтрэх заавар.



www.mail.e-mongolia.mn

■ Үндэсний цахим шуудан гэж юу вэ?

Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн бүр үндэсний цахим шууданг нээх боломжтой бөгөөд төрийн байгууллагад өргөдөл, гомдол, санал хүсэлтээ илгээх, мөн хариу мэдэгдэл хүлээн авах боломжтой цахим шуудангийн систем юм.



Заавар видео



Та энэхүү QR кодыг уншуулснаар цахим ур чадварын 6 модуль, 82 хичээлийг бие даан судлах боломжтой.



Бидэнтэй холбоо барих:



E Mongolia Academy



ema.gov.mn



+976-77111197



digitalskill@ema.gov.mn

Цахим ур чадварт суралцъя